

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 11 сарын 18 өдөр

№ 23/ХЭХ/14

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн төслийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Монложистикс Холдинг ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” хувьцаат компанийн дүрмийн төсөл (“Дүрэм”)–ийг хавсралтаар баталсугай.
2. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлэх болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Нарангарвуу/-д даалгасугай.
3. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Хишигбат)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХИШИГБАТ

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 11 сарын 18 өдөр

№ 23/ХТХ/15

Улаанбаатар хот

Г

Г

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалт, Монложистикс Холдинг ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн ердийн гишүүдээр дор дурдсан хамгийн өндөр саналын эрх авсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - 1.1. Лувсанжамбын Ганзоригт,
 - 1.2. Баастын Тэлэнгэд,
 - 1.3. Ганзоригтын Хишигбат,
 - 1.4. Балдангийн Энхтүвшин,
 - 1.5. Өлзийбаярын Ганзориг,
2. Компанийн ТУЗ–ийн хараат бус гишүүдээр дор дурдсан хамгийн өндөр саналын эрх авсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - 2.1. Санжаагийн Сайнбат,
 - 2.2. Эрэндоогийн Оюунбилэг,
 - 2.3. Готовын Цэрэнпүрэв,
 - 2.4. Сэнгээгийн Энх-Амгалан,
2. Энэхүү шийдвэр гарсантай холбоотойгоор өмнөх ТУЗ–ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь чөлөөлсүгэй.
3. Компанийн ТУЗ–ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Хишигбат)–д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХИШИГБАТ



МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 11 сарын 18 өдөр

№ 23/ХЭХ/16

Улаанбаатар хот

Г

Г

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл
ажиллагааны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, 62.1.15 дахь заалт, “Монложистикс Холдинг” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг дараах байдлаар баталсугай.

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор цалин урамшуулал	99,500,000
2	ТУЗ-ийн хурал	2,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	1,000,000
Дүн		102,500,000

2. Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Нарангарвуу/-д даалгасугай.
3. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХИШИГБАТ

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 11 сарын 18 өдөр

№ 23/УЭХ/17

Улаанбаатар хот

Г

Г

Гол ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн
хүрээнд опцион гаргах зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь заалт, “Монложистикс Холдинг” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн гол ажилтнуудыг урамшуулах зорилгоор энгийн хувьцаанд суурилсан, компанийн хувьцааг худалдан авч болох эрхийг баталгаажуулсан опцион гаргахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.
2. Дээрх хөтөлбөрийн хүрээнд Компаниас гарах үнэт цаас буюу опционыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ Хувьцаа эзэмшигчид нь хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
3. Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийгэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Нарангарвуу/-д даалгасугай.
4. Тус шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Компанийн гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХИШИГБАТ